

Бэлтгэх хуудас

Аж ахуйн нэгж байгуулж, улсын бүртгэлд бүртгүүлэхэд бүрдүүлэх бичиг баримт

Та шинээр аж ахуй нэгж байгуулах гэж байгаа бол үүсгэн байгуулж буй аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээс шалтгаалахгүйгээр доорхи материалуудыг бүрдүүлсэн байх шаардлагатай.

Үүнд:

- ☑ **Нэрийн сонголтын баталгаажуулалт** – Улсын бүртгэлийн албанд хандаж, өөрсдийн сонгосон оноосон нэр нь улсын хэмжээнд давхардаж буй эсэхийг шалгуулан, давхардаагүй тохиолдолд баталгаажуулна. Хэрэв давхардсан бол өөр оноосон нэрийн хувилбар гарган шалгуулна.
- ☑ **Тусгай зөвшөөрөл шаардлагатай үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бол холбогдох байгууллагаас авсан зөвшөөрөл** – Аж ахуйн нэгжийн эрхлэх гэж буй үйлдвэрлэл, үйлчилгээ нь «Тусгай зөвшөөрөл шаардагдах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн тухай хууль» -д тусгай зөвшөөрөл авахаар заасан бол хуульд заасны дагуу холбогдох байгууллагаас тусгай зөвшөөрөл авна. Тусгай зөвшөөрөл шаардагдах ажил үйлчилгээний төрөл, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр, утасны жагсаалтыг энэд хавсаргав.
- ☑ **Улсын бүртгэлийн тэмдэгтийн хураамж төлсөн баримт** – Аж ахуйн нэгж байрлах нутаг дэвсгэрийн орон нутгийн төсвийн орлогын дансанд «Тэмдэгтийн хураамжийн тухай хууль» -д заасны дагуу компани, нөхөрлөл 10000 төгрөг, хоршоо 6000 төгрөг, банк, даатгалын байгууллага 20000 төгрөг, улс төрийн нам, олон нийтийн байгууллага 10000 төгрөг тус тус тушаана.
- ☑ **Эхлэлтийн тайлан тэнцэл** – Аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулж буй хөрөнгийн нэр, төрлийг балансын дансдуудад харуулсан «эхлэлтийн тайлан тэнцэл» -ийг гаргана.
- ☑ **Аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулах өргөдлийн маягт** – Тус маягтыг Улсын бүртгэлийн албанаас авч, 2 хувь үйлдэнэ.
- ☑ **Үүсгэн байгуулагчдын анкет** – Анкетын маягтыг Улсын бүртгэлийн албанаас авч болох бөгөөд анкетанд зургаа наасан байна. Түүнчлэн анкетанд иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана.
- ☑ **Байрны түрээсийн гэрээ** – Аж ахуй нэгжийн оршин байрлаж буй хаягийг баталсан бичиг баримт болгож байрны түрээсийн гэрээг хавсаргана.